Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
2025 оны ..06.. дугаар сарын ..18..-ны өдрийн
..02/153.. дугаартай албан бичгийн хавсралт

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН "АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ"-НИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хэрэгжих хугацаа | Хүрэх түвшин, үр дүн | Зарцуулах хөрөнгө мян/төг | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | 1.Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | 1.1.Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг:<br>а/байгууллагын албан ёсны цахим хуудас;<br>б/сошиал сувгууд;<br>в/дотоод сүлжээ;<br>г/хэвлэл мэдээллийн хэрэгсэл;<br>д/мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц;<br>е/бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх; | -Тогтмол шинэчлэн, тогтвортой байршуулсан байх;<br>-Түгээсэн, хүрсэн үр дүнгийн талаар салбар хариуцсан ажилтанд тухай бүрт тайлагнадаг байх;<br>-Харьяа нэгжүүдийг нэгэн зэрэг хамруулж, үр дүнг нэгтгэн тайлагнаж хэвших;<br>-Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших. | Жилдээ | Сар бүр цахим хуудсанд байршуулах | | Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг байгууллагын албан ёсны цахим хуудасанд 4, сошиал сувгуудад 5, дотоод сүлжээнд 4-ыг сар бүр байршуулж, Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын пэйж хуудас болон албан хаагчид тус бүр өөрийн фэйсбүүк, твиттерт байршуулж иргэд олон нийтэд түгээж ажилласан. Мөн ажлын байранд авлигын эсрэг мэдээллийн самбар 1, авлигын эсрэг зурагт хуудсыг 6, албан хаагчдын өрөөний хаалга, компьютер зэрэгт авлигын эсрэг сурталчилгааны наалт 10-ыг тус тус байршуулж мэдээллээр хангаж ажиллаа. | 90 |
| | | 1.2.Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах | -Өдөрлөгт оролцсон иргэдээс байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт авч, түүнд үндэслэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байх;<br>-Авлигатай тэмцэх газраас өрнүүлж буй аян, уриалгатай уялдсан байх;<br>-Хамтран ажилласан байгууллага, хүний тоо;<br>-Үр дүнг тооцсон байх. | Жилдээ | 2 өдөрлөг, 1 аян | | "Улаанбаатар марафон-2025" олон улсын гүйлтийг үйл ажиллагааг "Авлигын эсрэг нэгдье" уриалгын дор зохион байгуулж авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар Нийслэлийн нутгийн захиргааны 87 байгууллагын 1512 албан хаагч, есөн дүүргийн хэлтэс, төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуй нэгжийн нийт 463 байгууллагын 8912 ажилтан албан хаагч болон нийт 30 мянга гаруй иргэдэд мэдээ мэдээлэл, сурталчилгааг явуулж ажилласан. | 100 |

| | | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1.3.Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал, зэрэгт авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчлах | -Мэдээллийг Авлигатай тэмцэх газраас буюу баталгаат эх сурвалжаас авсан байх;<br>-Байгууллагын эрх хэмжээний хүрээнд иргэд, олон нийт рүү чиглэсэн хэвлэмэл материалд оруулсан байх;<br>-Үр дүнг нэгтгэн тайлагнасан байх;<br>-Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших. | Сар бүр | 1200 ш гарын авлага тараах | | Нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын байгууллагаас зохион байгуулсан спортын уралдаан тэмцээний үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байх зорилгоор АТГ-аас бэлтгэсэн тв шторк 4, видео 3, теле зохиомж 3-ыг байгууллагын цахим хуудас, Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын пэйж хуудас болон албан хаагчид тус бүр өөрийн фэйсбүүк, твиттерт байршуулж иргэд олон нийтэд түгээж ажилласан. Түүнчлэн 613 ширхэг гарын авлага тарааж ажиллаа. | 90 |
| | | 1.4.Өөрсдийн байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий видео контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байх | -Авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх;<br>-Авлигын мэдээлэх 110 дугаарын утсыг сурталчилсан байх;<br>-Олон нийтэд түгээсэн байх. | 2, 3 дугаар улиралд | 12-оос доошгүй | | "Улаанбаатар марафон-2025" олон улсын гүйлтийн үйл ажиллагааны үеэр авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулж, сурталчилгааны ваннер, хулдаасан хэвлэл, асар майхан тохижуулж, авлигын мэдээлэх 110 дугаарын утсыг олон нийтэд сурталчилан таниулах зорилгоор олны танил гүйгчид 00110 энгэрийн дугаарыг олгож нийтдээ 30 мянга гаруй иргэнд түгээж ажиллаа. | 100 |
| 2. | 2. Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийн бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх | 2.1."Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх | -Журамд заасны дагуу өөрийн байгууллагын үйл ажиллагааны 1-ээс доошгүй чиглэлд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхээр сонгосон байх;<br>-Сонгосон чиглэлд олон нийтийг хяналтыг хэрэгжүүлэх сонгон шалгаруулалт зарласан байх; | Жилдээ | 1-ээс доошгүй | | Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ын дагуу байгууллагын албан ёсны цахим хуудсаар байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг ил тод нээлттэй мэдээлж хэвшсэн бөгөөд 2025 оны эхний хагас жилийн байдлаар зохион байгуулсан биеийн тамир, спортын 30-н ажил, үйлчилгээний 50 мэдээг sport.ub.gov.mn цахим хуудсанд байршуулж 3753 хүнд, "Нийслэлийн Биеийн тамир, спортын газар" пэйж хуудсанд 326 нийтлэл | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | -Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэн тайлагнах;<br>-Үр дүнд суурилсан арга хэмжээг зохион байгуулсан байх. | | | | байршуулж, 1,989,928 удаа хүргэж, 24779 удаа шэйр хийж, 80 рийлсийг 1,239,494 удаа үзэж, 56 зүйлийн 2820 зураг байршуулж 3,415,697 удаа үзсэн байна. Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа, цаг үеийн шаардлагатай мэдээ, мэдээллийг 735 удаа хувь хүн, байгууллагатай цахим шуудангаар мэдээ, мэдээлэл солилцсон. Улаанбаатар марафон, Улаанбаатар лиг, Иргэдийн спортын наадам, Нутгийн захиргааны байгууллагуудын спортын наадам, Цэцэрлэг, Сургуулийн Уран хөдөлгөөнт гимнастик зэрэг томоохон арга хэмжээнүүдийг олон нийтийн хяналтын хүрээнд зохион байгуулж холбогдох тайлан мэдээг дээд газруудад цаг хугацаанд нь хүргүүлж ажилсан. | |
| | | 2.2.Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх | -Салбарт бүрт үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудын нэгдсэн судалгааг гаргасан байх;<br>-Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ авсан байх;<br>-Үр дүнг тооцож, тайлагнасан байх. | Жилдээ | 4-өөс доошгүй | | Төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, спортын холбоодын үйл ажиллагааг дэмжих, тухайн төрлийн спортын төрлийг хөгжүүлэх зорилгоор 2025 онд үндсэн үйл ажиллагааны чиглэлээр төрийн байгууллага 13, ОУ-н байгууллага 3, төрийн бус буюу спортын 75 холбоо, хувийн хэвшлийн байгууллага 36 нийт 124 байгууллага, 4 иргэнтэй 8 төрлийн гэрээг 128 удаа байгуулж гэрээ байгуулж, авлигаас урьдчилан сэргийлэх заалтыг 8 дугаар зүйлд тусган хэрэгжүүлж ажилласан бол харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн хязгаарыг баримтлан ажиллаа. | 100 |
| | | 2.3.Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, | -2024 онд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар иргэд, олон нийтэд тогтмол ойлгомжтой | Жилдээ | 12-оос доошгүй нээлттэй мэдээлэх | | 2025 оны эхний хагас жилийн байдлаар Нийслэлийн Биеийн тамир, спортын газарт төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ төлөвлөгдөөгүй болно. | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах | байдлаар тогтмол мэдээлэх;<br>-Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой иргэд, олон нийтийн саналыг авч, холбогдох арга хэмжээг авах;<br>-Иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэх. | | | | | |
| | | 2.4.Байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших | -Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой гомдол, мэдээллийн судалгааг тогтмол гаргаж, тайлагнах;<br>-Хуулийн хүрээнд шуурхай, бодитой шийдвэрлэж хэвших;<br>-Иргэд, олон нийтээс Байгууллагын үйл ажиллагаа, хүнд суртал чирэгдэл, холбоотой гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх. | Жилдээ | 2-оос доошгүй | | Биеийн тамир, спортын чиглэлээр иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг 17 эх үүсвэрээр хүлээн авах зохицуулалтын дагуу 2025 оны эхний хагас жилд 19 өргөдөл, гомдол ирснийг шалтгаан нөхцөлийг тодорхойлж, холбогдох ажилтанд шилжүүлж, тухай бүр удирдлагад танилцуулж, шийдвэрлэлтэд хяналт тавьж, иргэний талд шийдвэрлэсэн 12, боломжгүй хариу өгсөн 7, шийдвэрлэлтийн дундаж 1 хоног 18 цаг 31 минут байна.<br>Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 11 өргөдөл, гомдлоор ихсэж, шийдвэрлэлтийн хугацаа 1 хоногоор буурсан үзүүлэлттэй байна. | 100 |
| | | 2.5.Улс, орон нутаг, гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлж байгаа төсөл, арга хэмжээний мэдээллийг | -MNS 7023:2023 "Мэдээллийн самбар"-т тавигдах шаардлага бүхий үндэсний стандартын | Жилдээ | Тухай бүр | | 2025 оны эхний хагас жилийн байдлаар манай байгууллагад улс, орон нутаг, гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлж байгаа төсөл, арга хэмжээ байхгүй болно. | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | | иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй болгох | хэрэгжилтийг улсын хэмжээнд хангуулах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах. | | | | | |
| 3. | 3.Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | 3.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах | -Нэвтрүүлсэн цахим үйлчилгээний чанар хүртээмжийн талаар иргэд, олон нийтээс судалгаа, санал асуулга авах;<br>-Дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх;<br>-Хэрэгжилтийг тайлагнах. | Жилдээ | 4-оос доошгүй | | Биеийн тамир, спортын үйлчилгээг цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр “Онлайн бизнес төв” платформын Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн /http://service.ulaanbaatar.mn/home/-ийн системд биеийн тамир, спортын салбарын 9-н үйлчилгээнээс “бассейн”, “фитнес, спининг”, “аэробик, иог, бүжгийн клуб”, “боулинг”, “бильярд” гэсэн 5 чиглэлийн үйлчилгээ орсон бөгөөд 2025 оны эхний хагас жилийн байдлаар давхардсан тоогоор 26-н аж ахуйн нэгж байгууллага, иргэнээс “бильярд”-ын холбогдолтой 22 хүсэлт бүртгүүлснээс зөвшөөрсөн 9, батлуулахаар шилж үүлсэн 5, буцаасан 6, татгалзсан 1, судлагдаж байгаа 1 хүсэлт байна, бассейнтэй холбоотой 1, фитнесстэй холбоотой 3 хүсэлт бүртгүүлсэн нь шаардлага хангаагүй буцаагдсан байна.<br>Үлдсэн 4 үйлчилгээг системийн 2-р хувилбарт оруулах талаар саналаа хүргүүлж, уулзаж ярилцаж, албан бичиг хүргүүлсэн болно. | 100 |
| | | 3.2.Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх | -Албан хаагчидтай холбогдуулан ирүүлсэн авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг Авлигатай тэмцэх газарт шилжүүлж хэвших;<br>-Албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад чиглэсэн арга хэмжээг | Жилдээ | Тухай бүр | | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийн /erp.ulaanbaatar.mn/-ын байрших: Хүний нөөцийн системүүдийг өдөр бүр үйл ажиллагаандаа бүрэн ашиглан хяналт тавин ажиллаж байна.<br><br>2025 оны эхний хагас жилийн байдлаар манай байгууллагын ажилтан албан хаагчидтай холбогдуулан ирүүлсэн авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, мэдээлэл ирээгүй болно. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан эрсдэлийг тодорхойлсон байх;<br>-Эрсдэлийг арилгах арга хэмжээнд дотоод хяналтын үйл ажиллагааг зохион байгуулсан байх. | | | | | |
| | | 3.3.Нийслэлийн хэмжээнд Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах | -Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх;<br>-Албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг тусгасан байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Жилдээ | | | Нийслэлийн хэмжээнд Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний саналыг нэгтгэж 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр байгууллагын даргаар батлуулсан. Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны эхний хагас жилийн биелэлтийг албан хаагчдаас авч нэгтгэж, удирдлагад танилцуулж, хугацаанд нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхээр боловсруулалт хийгдэж байна. | 100 |
| | | 3.4.Хүүхдийн шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах | -Сургалт, нөлөөллийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх. | Жилдээ | | | Улаанбаатар марафон олон улсын гүйлт, "Улаанбаатар лиг" сагсан бөмбөг, волейболын тэмцээн, Цэцэрлэг, Сургуулийн Уран хөдөлгөөнт гимнастик зэрэг томоохон арга хэмжээнүүдийн үеэр хүүхдийн шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэлээр Нийслэлийн Боловсролын газар болон Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газартай хамтран сургалт зохион байгуулж 8652 сурагчдыг хамруулллаа. | 100 |
| | | 3.5.Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төлөвлөгөөнд санал өгөх, хэрэгжилтийг зохион байгуулах, | -Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас санал авч, нэгтгэн хүргүүлсэн байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Жилдээ | | | Нийслэлийн Биеийн тамир, спортын Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 2025 оны эхний хагас жилд арга хэмжээ (Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын "Улаанбаатар лиг" сагсан бөмбөгийн техникийн зөвлөгөөн, Цэцэрлэгийн хүүхдүүдийн Уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээнүүдийн техникийн | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зөвлөгөөн, Ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын багш, арга зүйчдийг чадавхжуулах сургалт, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын биеийн тамирын багш, арга зүйчдэд зориулсан чадавхжуулах сургалт, Хөгжөөн дэмжигчдийн сургалт, ”Улаанбаатар марафон-2025” олон улсын гүйлтийн техникийн зөвлөгөөн) зохион байгуулахад оролцсон нийт 416 багийн 1076 багш, арга зүйчдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 17 дугаар зүйл, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.3, 9.9 дэх заалт, Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хэм хэмжээг танилцуулж, мэдээллээр хангаж ажилласан. | |
| | | 3.6.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа, дүрмээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмол хийх | -Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;<br>-Дүгнэлт зөвлөмж гаргасан байх. | Жилдээ | | | Байгууллагын үйл ажиллагаа, дүрмээр хүлээсэн үүргийн биелэлт, бодлогын баримт бичигт хяналт шинжилгээ, үнэлгээ хийх 12 ажил бүхий төлөвлөгөөг байгууллагын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, захиргааны байгууллагын үйл ажиллагааны 12 /давхардсан тоогоор/ тайлан, мэдээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээр төлөвлөн явцын хяналт-шинжилгээг 8 тайланд хийсэн бөгөөд боловсруулалт хийгдэж байгаа 4 тайлан байна. | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 3.7.Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах эх үүсвэрийг нэмэгдүүлж, шийдвэрлэлтийн чанар, үр дүнг сайжруулах | -Эх үүсвэрийн тоог нэмэгдүүлж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хяналтыг сайжруулж, 7 хоног тутам мэдээ, мэдээллийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтнуудад танилцуулах. | Жилдээ | | | Биеийн тамир, спортын чиглэлээр иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг 17 эх үүсвэрээр хүлээн авах зохицуулалтын дагуу 2025 оны эхний хагас жилд 19 өргөдөл, гомдол ирснийг шалтгаан нөхцөлийг тодорхойлж, холбогдох ажилтанд шилжүүлж, тухай бүр удирдлагад танилцуулж, шийдвэрлэлтэд хяналт тавьж, иргэний талд шийдвэрлэсэн 12, боломжгүй хариу өгсөн 7, шийдвэрлэлтийн дундаж 1 хоног 18 цаг 31 минут байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 11 өргөдөл, гомдлоор ихсэж, шийдвэрлэлтийн хугацаа 1 хоногоор буурсан үзүүлэлттэй байна. | 100 |
| | | 3.8.Нийслэлийн удирдах ажилтны шуурхай хуралдаанаар өгсөн үүрэг даалгавар, Засаг даргын захирамжийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах | -Засаг даргын захирамж, ажлын хэсэг, албан тушаалтанд өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцсон байх. | Жилдээ | | | Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 2025 оны эхний хагас жилийн байдлаар 8 удаагийн хуралдаанаар 30 үүрэг даалгавар өгөгдсөнг цаг хугацаанд нь бүрэн тайлагнаж, өгсөн үүрэг даалгаврын 89,3 хувьтай хэрэгжилтийг хангаж ажилласан. Манай байгууллагад хамраалтай Нийслэлийн Засаг даргын 8 захирамжийг хяналтад авч хэрэгжилт 100% биелэсэн. | 100 |
| | | 3.9.Худалдан авах ажиллагааны А3 сургалтад хамрагдах албан хаагчийн тоог нэмэгдүүлэх | -Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо. | Жилдээ | 100 | | Худалдан авах ажиллагааны А3 сургалтад 2 албан хаагчийг хамруулахаар хүсэлт хүргүүлж 1 албан хаагчийг сургалтад хамруулсан. | 100 |
| | | 3.10.Байгууллагын төсөв, санхүүгийн сахилга, батыг сайжруулах | -Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хуулийг хэрэгжилтийг хангаж, төрийн сангийн үйл ажиллагаанд хяналтыг тогтмол хийж хэвшсэн байх. | Жилдээ | | | Байгууллагын батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, өр авлага үүсгэлгүй ажиллаж сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайланг хугацаанд нь дээд байгууллагуудын хүргүүлж ажилласан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 3.11.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт зохион байгуулах | -Нийслэлийн удирдах албан тушаалтнуудад зориулсан сургалт зохион байгуулсан байх;<br>-Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдад зориулсан сургалт зохион байгуулсан байх;<br>-Нийслэлийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн албан хаагч нарт зориулсан сургалт зохион байгуулсан байх;<br>-Иргэний нийгмийн байгууллага (Иргэн, сонирхлын бүлэг, ТББ, мэргэжлийн холбоо г.м)-д чиглэсэн сургалт зохион байгуулсан байх;<br>-Хувийн хэвшилд зориулсан сургалт зохион байгуулсан байх. | Жилдээ | | | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр ССАЖЗЯам, Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас албан хаагчдад зориулан зохион байгуулсан 4 удаагийн сургалтад давхардсан тоогоор 37 албан хаагчийг хамруулсан.<br>Авлигатай тэмцэх газраас 2025 оны 03 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд зохион байгуулсан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургагч багш бэлтгэх сургалтад Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга хамрагдан суралцаж сургагч багшийн гэрчилгээ эзэмшиж нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын байгууллагын ажилтан, албан хаагчдад 1 удаагийн сургалт зохион байгууллаа. | 100 |
| | | 3.12.Төрийн болон албаны нууцын тухай, хадгалалт хамгаалалт талаар сургалт зохион байгуулах | -Нийслэлийн удирдах албан тушаалтнуудад зориулсан сургалт зохио<br>н байгуулсан байх;<br>-Нэгдсэн төслийн удирдлагын газар ОНӨТҮГ-ын албан хаагчдад зориулсан зохион байгуулсан байх. | Жилдээ | 2-оос доошгүй | | ССАЖЗЯ-аас 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан “Төрийн болон албаны нууцын тухай, хадгалалт хамгаалалт” сэдэвт сургалт 2 удирдах албан хаагч хамрагдаж, байгууллагын ажилтан, албан хаагчдад сургалтын талаарх мэдээ мэдээллийг өгсөн. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 3.13.Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, үр дүн тооцох, холбогдох арга хэмжээ авч хариуг хүргүүлэх | -АТГ-аас хүргүүлсэн мөрдөгчийн мэдэгдлийн мөрөөр үр дүнтэй ажиллах, үр дүнг тооцож хүргүүлэх;<br>-АТГ-аас хүргүүлсэн зөрчил арилгуулах албан бичгийн мөрөөр үр дүнтэй ажиллах, үр дүнг тооцож хүргүүлэх;<br>-Тухай байгууллагатай холбоотой хэвлэл мэдээллийн мөрөөр АТГ-тай хамтран ажиллах, холбогдох баримт бичгийг гаргаж хүргүүлэх;<br>-Тухай байгууллагын үйл ажиллагаанд тандалт, дүн шинжилгээ хийхэд АТГ-тай хамтран ажиллах, холбогдох баримт бичгийг гаргаж хүргүүлэх;<br>-Тухай байгууллагын үйл ажиллагаатай холбоотой АТГ-т өргөдөл, гомдол, мэдээлэл ирэхэд хамтран ажиллах, холбогдох баримт бичгийг гаргаж өгөх. | Жилдээ | Тухай бүр | | 2025 оны эхний хагас жилийн байдлаар манай байгууллагын үйл ажиллагаа болон ажилтан албан хаагчид гаргасан зөрчил дутагдал байхгүй бөгөөд Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн мөрдөгчийн мэдэгдэл болон зөвлөмж ирээгүй болно. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 3.14.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах, шинээр батлах дүрэм, журмын жагсаалтыг гаргаж, Авлигатай тэмцэх газраас санал авч, тусгасан байх | -АТГ-аас ирүүлсэн зөвлөмж, албан бичгийн дагуу хариуг хүргүүлж, өөрчлөх, хүчингүй болгох;<br>-Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас санал авч, нэгтгэн хүргүүлсэн байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Жилдээ | Тухай бүр | | 2025 оны эхний хагас жилийн байдлаар бодлогын баримт бичиг нийт 5 удаа санал боловсруулан албан тоотоор холбогдох байгууллагуудад хүргүүлж ажиллаа. Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, байгууллагын чиг үүргийн дагуу тусгах ажлын саналыг боловсруулан тайлбар, танилцуулгын хамт холбогдох байгууллагуудад хүргүүлж тусгуулж ажилласан. | 100 |
| | | 3.15.Улаанбаатар хотод хэрэгжүүлэх Мега төслүүдийн хэрэгжилтэд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, хяналт тавьж ажиллах | -АТГ-тай хамтран Мега төслүүдийн хэрэгжилтэд хяналт тавьж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлыг зохион байгуулах. | Жилдээ | Тухай бүр | | Улаанбаатар хотод хэрэгжүүлж байгаа Мега төслүүдэд 2025 оны эхний хагас жилийн байдлаар манай байгууллага хяналт тавьж хэрэгжүүлэх төсөл байхгүй болно. | 100 |

ТАНИЛЦСАН:
НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ (С.САРАНЦЭЦЭГ)

ТАЙЛАГНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА (М.ЦОГЗОЛМАА)

# НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ЭБАТ-НЫ 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2025 оны 06 дугаар сарын 10 Улаанбаатар хот

Нийслэлийн Биеийн тамир, спортын газар нь 2025 онд Авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр 3 зорилт 24 арга хэмжээтэй нэгдсэн төлөвлөгөө батлан хэрэгжүүлж эхний хагас жилийн биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

Нийслэлийн Биеийн тамир, спортын газар болон 9 дүүргийн Биеийн тамир, спортын хороодын ХАСХОМ–ын 2024 оны мэдүүлгийг шинэчлэн гаргах 41 албан хаагчдыг хуулийн хугацаанд мэдүүлгийг гаргуулж, баталгаажуулан Биеийн тамир, спортын Улсын хороонд 2025 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 2/72 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр ССАЖЗЯам, Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас албан хаагчдад зориулан зохион байгуулсан 4 удаагийн сургалтад давхардсан тоогоор 37 албан хаагчийг хамруулсан.

Авлигатай тэмцэх газраас 2025 оны 03 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд зохион байгуулсан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургагч багш бэлтгэх сургалтад Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга хамрагдан суралцаж сургагч багшийн гэрчилгээ эзэмшиж нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын байгууллагын ажилтан, албан хаагчдад 1 удаагийн сургалт зохион байгууллаа.







Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг байгууллагын албан ёсны цахим хуудасанд 11 сошиал сувгуудад 12, дотоод сүлжээнд 12-ыг 7 хоног тус бүр байршуулж, Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын пэйж хуудас болон албан хаагчид тус бүр өөрийн фэйсбүүк, твиттерт байршуулж иргэд олон нийтэд түгээж ажилласан. Мөн ажлын байранд авлигын эсрэг мэдээллийн самбар 1, авлигын

эсрэг зурагт хуудсыг 11, албан хаагчдын өрөөний хаалга, компьютер зэрэгт авлигын эсрэг сурталчилгааны наалт 11-ыг тус тус байршуулж мэдээллээр хангаж ажиллаа.




Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ын дагуу байгууллагын албан ёсны цахим хуудсаар байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг ил тод нээлттэй мэдээлж хэвшсэн бөгөөд 2025 оны эхний хагас жилийн байдлаар зохион байгуулсан биеийн тамир, спортын 30-н ажил, үйлчилгээний 50 мэдээг sport.ub.gov.mn цахим хуудсанд байршуулж 3753 хүнд, "Нийслэлийн Биеийн тамир, спортын газар" пэйж хуудсанд 326 нийтлэл байршуулж, 1,989,928 удаа хүргэж, 24779 удаа шэйр хийж, 80 рийлсийг 1,239,494 удаа үзэж, 56 зүйлийн 2820 зураг байршуулж 3,415,697 удаа үзсэн байна. Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа, цаг үеийн шаардлагатай мэдээ, мэдээллийг 735 удаа хувь хүн, байгууллагатай цахим шуудангаар мэдээ, мэдээлэл солилцсон.

Нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын байгууллагаас зохион байгуулах үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байх зорилгоор Авлигын эсрэг "МЭДЬЕ, НЭГДЬЕ" аянд нэгдэж Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем erp.ulaanbaatar.mn болон байгууллагын цахим хуудсанд байгууллагын албан хаагчдыг оролцуулсан 1 минутын бичлэгийн сурталчилгааг хийж орууллаа.



2025 оны 05 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулсан “Улаанбаатар марафон-2025” олон улсын гүйлтийн үйл ажиллагааны үеэр авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулж, сурталчилгааны ваннер, хулдаасан хэвлэл, асар майхан тохижуулж, авлигын мэдээлэх 110 дугаарын утсыг олон нийтэд сурталчилан таниулах зорилгоор олны танил гүйгчид 00110 энгэрийн дугаарыг олгож ард иргэдэд сурталчилсан бөгөөд Нийслэлийн нутгийн захиргааны 87 байгууллагын 1512 албан хаагч, есөн дүүргийн хэлтэс, төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуй нэгжийн нийт 463 байгууллагын 8912 ажилтан албан хаагч болон нийт 30 мянга гаруй иргэдэд мэдээ мэдээлэл, сурталчилгааг хүргэж ажилласан.




2025 оны 12 дугаар сарын 18-ны байдлаар манай байгууллагын үйл ажиллагаатай холбоотой болон албан хаагчдад авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой ямар нэгэн гомдол, зөрчил, маргаан бүртгэгдээгүй болно.

ТАЙЛАН ГАРГАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА М.ЦОГЗОЛМАА

9024010069 СТС4588 9077448